



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/20

Амардалай

Г Хязгаарлалтын дэглэмийг цуцлах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2. 17.2.1 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоол, хорин цээр, хязгаарлалтын дэглэм хэрэгжүүлэх журам үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Цахиурт багийн нутаг "Шугамын хөх" /N46°31'08"4/ / E106°18'22"7/ солбицол бүхий газарт гарсан малын гоц халдварт хонины цэцэг өвчний хорио цээрийн дэглэмийн цуцалж хязгаарлалтын дэглэмд шилжүүлсэн 14 хоногт малын өвчлөл илрээгүй тул хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.

2. Хязгаарлалтын дэглэм цуцалсан газар нутгийн малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ард иргэд, малчдыг хонины цэцэг өвчнөөс урьдчилсан сэргийлэх, мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (Д.Наранцэцэг)-т үүрэг болгосугай

ДАРГА

М.БАЯРСҮХ

